



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар A/253

Улаанбаатар хот

### Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар (Д.Батцэцэг)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 200,000,000.0 (хоёр зуун сая) төгрөгийг "Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын "41"-д заасан "Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолбор, музейн барилгын зураг төсөв, цахилгааны эх үүсвэрийн ажил (Улаанбаатар хот)"-ын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханганд ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/20 дугаар захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын "7" дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

*Х.Нямбаатар*

Х.НЯМБААТАР

1725021206

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
03 дугаар сарын 20 нь өдрийн  
1253 дугаар захирамжийн  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейн зураг төсөв (Улаанбаатар хот)	2025	2025	160.0	160.0
2	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын цахилгааны эх үүсвэрийн ажил (Улаанбаатар хот)	2025	2025	40.0	40.0
ДҮН				200.0	200.0





ଅନୁମତିଦ୍ୱାରା ପ୍ରକାଶିତ ଏବଂ ଉପରେ  
ହାତରେ ଲାଗିଥାଏ କଣ୍ଠରେ କାହାରେ

ରୁ... ନୁମତିଦ୍ୱାରା

ବିବରଣୀରେ ଲାଗିଥାଏ ଏବଂ କଣ୍ଠରେ କାହାରେ କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା ..  
୦୭ ଟଙ୍କା ..  
୧୦୨୦ ଟଙ୍କା ଟଙ୍କା ଟଙ୍କା ଟଙ୍କା ଟଙ୍କା ..

ବିବରଣୀରେ କାହାରେ କିମ୍ବା ..

ହାତରେ ଲାଗିଥାଏ କାହାରେ କାହାରେ ..  
କାହାରେ କାହାରେ ..

ବିବରଣୀରେ କାହାରେ ..

ବିବରଣୀରେ ..  
(୦୦ .. କାହାରେ ..) -୨୩ ଟଙ୍କା ଟଙ୍କା ..  
ବିବରଣୀରେ ..  
(୦୦ .. କାହାରେ ..) -୨୩ ..